

Германд насан туршдаа төрийн алба хаадаг (Тэмдэглэл- Сургамж)

Ц. Ганхуяг

Пруссын Эзэнт улсын үеэс төрийн албан хаагчдаа хүндэтгэлтэй ханддаг зарчим өнөөг хэрнээ хадгалагдаж байгааг сонсоход үнэхээр биширмээр. Үүнийг герман соёл гэх байх. Германд төрийн албан хаагч намын гишүүн байж болно. Гэхдээ үлс төрийн үзэл бодлоо даруу илэрхийлэх, аль нам гэдгээ ил тод байлгах, хэрэгтэй гэж үздэг. Улс төрийн намын гишүүн төрийн албан хаагчийн хувьд биеэ хэрхэн зөв авч явах эсэх нь тэр хүний өвөлөөс ихээхэн хамаардаг аж. Германчууд намын харъяалалыг нууцлах нь сөрөг нөлөөтэй гэж үзнэ.

Улс бүр өөр өөрийн онцлогтой төрийн албаны бодлого явуулдаг. Англид төрийн албан хаагч намын гишүүн байх нь хориотой төдийгүй тэднийг халж, солихыг зөвшөөрдөггүй бол Скандиновын орнуудад төрийн албан хаагч гэсэн статус байхгүй, төрийн албан хаагчдын цалин хөлс, нийгмийн хамгааллын харилцааг тарифын гэрээгээр зохицуулдаг байна.

Харин эртний соёлт Германд энэ бүгдийн алтан дундажийг барьсан насан туршийн төрийн албан хаагчийн номлол хэрэгждэг байна. "Төрөөс төрийн албан хаагчийн амьдрах боломжийн цалин хангамж эдлүүлнэ" гэсэн энгийн боловч тодорхой хуультай учир төр эрхээ төрийн албан хаагч насан туршдаа эдэлнэ.

Төрийн албан хаагчаар томилогдсон л бол тэтгэвэрт гартлаа энэ статусаа хадгалж, чөмгөө дундартал зүтгэх төрийн жинхэнэ хар хүн болдог аж. Хэрэв хууль зөрчсөн, ёс зүйн алдаа эндэгдэл гаргахгүй бол хэн ч таны ажил, албан тушаалыг хөндөж чадахгүй. Гэхдээ төрийн албан хаагчийг ажлаас нь халах ажиллагаа хэн эрх барьж байгаагаас их хамаарна. Удирдах алба хашиж байгаа буюу намны төрийн нарийн бичгийн дарга, газар, хэлтсийн дарга нар л энэ дайралтад өртдөг. Гэхдээ халагдсан тэдэнд төрөөс цалингаас 72 хувьтай тэнцэх тэтгэмж сар бүр өгнө. Бас тэтгэвэрийн санд төрөөс 100 хувь шимтгэл өгнө. Насан туршийн төрийн албан хаагчийн баталгаа нь энэ юм. Халагдсан төрийн албан хаагчийн оронд ажиллах хүн тангараг өргөсөн төрийн албан хаагч л байна. Төрийн албан хаагч намын гишүүн байж болно. Нам нь ялж түүний

эгүүлэн томилох хүртэл авч байсан цалингийнхаа 72 хувьтай тэнцэх тэтгэлгээ аваад өөр ажил эрхэлж болно, намынхаа төрийн албан хаагчийн нөөцөд орно.

Германд өндөр ёс суртахуун, хуульт ёс нь хүний амьдралын хэм хэмжээ болсон байна. Тэнд том дарга нь хууль бус үйлдэл хийхийг төрийн албан хаагч аас шаардвал “Уучлаарай, таны шаардлагыг хүлээж авах боломжгүй” гэж хэлээд л гарна. Том даргын үгээр явсангүй гээд түүнийг ажлаас нь халах, өөрчлөх ахул том дарга өөрөө хэрэгт ордог тийм дархлаа бий болсон байна. Төрийн албан хаагч нь хулийг шудрагаар хэрэгжүүлэгч болохоос хэн нэгний далайсан газар нь далд орж, далласан газар нь ил гардаг хамелеон биш ажээ.

Германд хээл хахуультай тэмцэх хууль маш нарийн зохион байгуулалттай. Түүнээс бултана гэдэг хэцүү. Орлогын мэдүүлгийг маш нарийн, дэлгэрэнгүй авна. Тендерийн мөнгийг хэдхэн хоног өөр дансанд хадгалж байгаад шилжүүлэг хийн баригдсан нэгэн төрийн албан хаагч насан туршийн төрийн албан хаагч байх эрхээ хасуулаад зогсохгүй, 8 жилийн ял авсан байгаа юм. Ийм жишээ тэнд тун ховор. Төрийн албан хаагч ажил хаях эрхгүй, тэтгэврийн шимтгэлийг төсвөөс 100 хувь төлдөг ба төрийн албан хаагчийн харилцааг зөвхөн хуулиар зохицуулна. Үүгээр төрийн албан хаагч тарифын гэрээт албан хаагчаас ялгагддаг байна.

Төрийн албан хаагчдаас парламентын чадварлаг гишүүд төрнө

Төрийн албан хаагч байснаас хувийн хэвшилд ажиллах нь илүү цалин хангамж, эрх чөлөө эдэлдэг тэгээд ч төрийн албанд ороход тун хэцүү гэж үзнэ.

Хувийн хэвшилд төрийн алба шиг карьер хөөх тогтсон зарчим байхгүй, ажлын үр дүнгээр цалинжина, албан тушаал ахина, буурна. Компани ашигтмай ажиллавал дагаад амьдрал дээшилнэ. Германд хувийн хэвшлийнхэн улс төрийг маш их сонирхоно, гэхдээ улс төрч болохыг эрс цээрлэнэ. Тэдэнд улс төрч болж олны өмнө ил байх нь бизнесийг нь бусниулж улмаар компаны хувьцааны борлуулалтад муугаар нөлөөлдөг тул “хөшигний арын” ажиллагааг илүүтэйд үзнэ. Төрийн алба нь нэг талаас зарчимч,

өндөр соёлын ажил учраас цаг үргэлж үр ашгийн төлөө тэмүүлэх ажил хэрэгч хүмүүст "зохиогүй чимэг" болдог аж.

Германы парламентын гишүүдийн бараг тал нь өмнө нь төрийн албан хаагчаар ажиллаж байсан хүмүүс байдаг. Тэд улс төрийн албан хаагч болтлоо төрийн албан хаагчин статусаа хадгална. Сонгогдох хүртлээ гэсэн үг. Парламентын гишүүнээр ажиллаад дараагийн удаа сонгогдохгүй бол эргээд төрийн албан хаагчийн статус нь сэргэдэг аж. Учир нь Германд төрийн албан хаагчийг насан туршид нь томилдог зарчимтай учраас тэр.

Хууль тогтоох байгууллагаад боловсрол, туршлага, шударга зан чанар, эгэл олноо энэрэн хайрлах сэтгэл зүрхтэй хүмүүс очих нь зөв гэдгийг герман соёл харуулж байна.

Ахин дэвшдэг төрийн албан хаагч

1996 онд миний бие Япон улсын Гадаад яамны урилгаар Япон улсад айлчлах үед төрийн албандаа Германы ахин дэвшдэг зарчмыг хэрэгжүүлдэг тухайгаа төрийн албан хаагчид нь ярьж байсан. Япон улс бол Германы Иргэний хуулийг үндсэнд нь хуулбарлан хэрэгжүүлсэн гэдэг. 1960-70-аад оны япон эмч нар нилээд нь герман хэлтэй, анагаах ухааны голлох сурах бичиг нь герман хэл дээр байдгийг хүмүүс мэднэ.

Германд өрийн албан хаагч хэдэн насандаа ямар албан тушаалд хүрэхээ төсөөлсөн байдаг. Жишээлбэл, хэд хэдэн хэлтэст ажиллах замаар салбарынхаа түвшинд универсаль мэргэжилтэн болж, хэлтсийн орлогч даргаар ажиллах шалгуур давдаг байна. Энэ зарчим л бүх албан тушаалд томилоход баримтлагдана.

40-45 насандаа рефератын дарга болохоо төрийн албан хаагч ажилд орсон өдрөө л мэдэж байдаг. Ийм улсад төрийн албан хаагч 50 нас хүрсэн бол яамны газрын даргын зиндаанд хүрлээ гэж үзнэ. Тэгээд тийм цалин хангамж олгоно, албанд нь томилно.

Төрийн албанд өндөр боловсрол хэрэгтэй

Улс төрийн намын гишүүн гэхээсээ илүү тэр хүн хэр чадвартай вэ гэдэгт гол анхаарлаа төвлөрүүлдэг байна. Төрийн албанд

орно гэдэг нь ч тийм амар хэрэг биш. Төрийн албан хаагчдын тасралтгүй сургалтад хамруулах, их, дээд сургуулийн төгсөлтийн шалгалт лугаа хатуу чанга шалгуураар авч үздэг байна.

Шалгалтыг улсын тусгай комисс авна. Шалгуурын оноонд хүрвэл ажилд орох тэрх нээгдлээ гэсэн үг. Өмнө нь ажиллаж байсан байгууллагын даргын тодорхойлолт эсвэл түүнээс илүүтэйгээр хамт олны зөвлөлийн тодорхойлолтыг их анхааралтай авч үзнэ. Германчууд төрийн албан хаагчдыг давтан сургах системийг гайхалтай нэвтрүүлж чаджээ. 3 жил хүртэл сургах хөтөлбөр ч байдаг аж. Засгийн газар нь хууль хэрэгжүүлэгч учраас төрийн албан хаагчдаас хууль зүйн мэдлэг их шаардана. Удирдах албан тушаалд ажиллаж байгаа төрийн албан хаагчдын 60 хувь нь хууль зүйн, 14 хувь нь эдийн засгийн боловсролтой, үүн дотор Төрийн нарийн бичгийн дарга нарын 31 хувь хууль зүйн боловсрол эзэмшжээ.

Герман улс холбооны хэмжээндээ төрийн албаны шалгаруулалт хариуцсан нэгж байдаггүй, шалгаруулалтыг тухайн субъект өөрөө хариуцна. Дотоод яам нь төрийн албаны хууль эрх зүй, нийтийн тусын эрхэм дээд ажил үүргээ л хариуцдаг аж.

Төрийн нарийн бичгийн даргыг ажлаас нь халж, чөлөөлж болно.

Төрийн нарийн бичгийн дарга нь яамыг сайдтай, парламенттай холбож өгдөг чухал албан тушаал юм. Германд нэг яам 2-3 Төрийн нарийн бичгийн даргатай байдаг. Яамандаа ажил үүргээ гүйцэтгэх Төрийн нарийн бичгийн даргаас гадна Засгийн газраас нь томилсон парламент дахь тухайн салбарын асуудлыг хариуцсан депутат-Төрийн нарийн бичгийн дарга ажиллана. Яамандаа ажил үүргээ гүйцэтгэх Төрийн нарийн бичгийн даргаас гадна Засгийн газраас нь томилсон парламент дахь тухайн салбарын асуудлыг хариуцсан депутат-Төрийн нарийн бичгийн дарга ажиллана.

Сайд нь цаг үргэлж парламентад дуудагдан хайран цагаа үрдэг учраас депутат-Төрийн нарийн бичгийн дарга гэсэн орон тоо бий болгожээ. Депутат-Төрийн нарийн бичгийн дарга нь тухайн яамны сайдын өмнөөс мэдэгдэл хийх, байнгын хороодын хурал

дээр яамаа төлөөлөх, бас ч ирээдүйн сайд болох "замаа засах" зорилготой захиргааны гэхээсээ илүү улс төрийн ач холбогдолтой албан тушаал юм.

Депутат төрийн нарийн бичгийн дарга нь депутатын цалин хангамжаа эдлэхээс гадна Төрийн нарийн бичгийн даргын цалин дөвхөр авна. Манайх шиг хоёр албан тушаалыг нэг цалинг нь өгвөл боллоо гэсэн хоосон шударга дүр огт хэрэггүй бөгөөд цалингийн цаана хариуцлага байгаа гэдгийг тэд илүү хардаг байна. Төрийн нарийн бичгийн дарга нь ихэвчлэн сонгуулийн үр дүнгээр өөрчлөгддөг. Түүнээс биш манайхан шиг "би хуулийн дагуу сайн ажилласан" гээд хичнээн зүтгээд ч нэмэргүй.

Төрийн нарийн бичгийн дарга тухайн яам, салбараа хэрхэн оновчтой, адварлаг удирдахаас сайдын ажлын үзүүлэлт улмаар Засгийн газрын нэр хүнд шууд хамаардаг тул энэ хариуцлагатай албанд "өөрийн хүн"-ээ тавьдаг байна. Гэхдээ яамны төрийн нарийн бичгийн даргаар ажиллах хүн заавал төрийн албан хаагч байна. Манайх шиг үүрэг гүйцэтгэгч төрийн нарийн бичгийн дарга томилсныхоо дараа төрийн албаны шалгалт "өгүүлэн" жинхэлдэг өс энд алга.

Ялсан нам төрийн албан хаагч бүхий намын гишүүдээсээ л Төрийн нарийн бичгийн даргыг томилно. Тоглоомын дүрэм тодорхой байгаа биз. Энд насан туршийн төрийн албан хаагч гэдэг зарчим хэн ч Засгийн эрхэнд гарсан адил үйлчилнэ.

Чөлөөлөгдсөн төрийн нарийн бичгийн дарга ажилтай болтлоо хэл ам гаргалгүй цалингийн 72 хувийн тэтгэлгээ аван төрөөс тэтгэвэрийн санд 100 хувь шимтгэл төлөн ажилд орохоо хүлээн суудаг ба бас хувийн хэвшилд ажил хийхийг нь зөвшөөрдөг аж. Ардчилсан холбоо намын дарга Гельмут Коль Засгийн эрхийг тэргүүлсэн 16 жилийн дараа социал демократууд 1998 онд гарч ирэнгүүтээ Төрийн нарийн бичгийн дарга нарын 96 хувь, газар, хэлтсийн дарга нарын 57 хувийг сольжээ. Социал демократууд энэ том халаа сэлгээг хийхдээ өөрийн намын харъяалалд байгаа насан туршийн төрийн албан хаагчдаасаа л сонгож томилжээ.

Төрийн нарийн бичгийн даргын цалин төрийн албан хаагчдын жишиг цалин болдог.

Төрийн нарийн бичгийн даргын цалин түүнээс доод эсвэл дээд албан тушаалын жишиг цалин нь болдог. Ийм албан тушаалтан сар бүр 10 353,56 еврогийн цалин авна. Манай мөнгөөр бол 17,2 сая төгрөг. Гэхдээ энэ цалингаасаа татвар төлнө. Ойролцоогоор 10 гаруй сая төгрөгийн бодит цалин авна гэгсэн үг. Энэ жишиг цалингаас 2 сая төгрөгөөр бага цалинг газар, хэлтсийн дарга нар авна. Харин Ерөнхий сайд жишиг цалингаас 1,9 дахин илүү буюу бараг 20 сая төгрөгийн цэвэр цалин авна.

Төрийн нарийн бичгийн даргын цалин өсвөл бусдынх нь дагаад өснө гэсэн үг. Цалинг өсгөхдөө эхний 2 жил дараагийн 3 жил гэх зэргээр үе шаттай авч үздэг байна. Цалингаас гадна гэр бүлтэй бол 100-105 еврог сар бүр, 1-2 хүүхэдтэй айлын хүүхэд бүрт сар бүр 90 евро, 3 хүүхэдтэй айлын хүүхэд тутамд сар бүр 230 евро олгодог аж.

Төрийн албан хаагч 65 нас хүрч тэтгэвэрт гарснаар насан туршийн төрийн албан хаагчийн статус дуусгавар болно. Тэтгэврийг зөвхөн үндсэн цалингаас боддог тул нэмэгдэл үүнд хамаарахгүй. Гэхдээ цалин ба нэмэгдэл нь татварт хамаарагдана. Энгийн болон дунд түвшний төрийн албан хаагчийн гэр бүл сар бүр 100 евро, хүндэт болон дээд түвшний төрийн албан хаагчийн гэр бүлд 105 еврог сар бүр олгоно. Төрийн албан хаагч нь 1 эсвэл 2 хүүхэдтэй бол хүүхдийн тоогоор сар бүр 90 евро, харин 3 хүүхэдтэй бол сар бүр хүүхэд бүрээр 230 евро олгодог аж.

Томгоо үз

Төрийн албаны баялаг туршлагатай Германы жишээг монгол төрийн албыг бэхжүүлэх, төлөвшүүлэхэд ач холбогдол өгч анхааран үзэх хэрэгтэй санагдаж байна. Төрийн чадварлаг албатай байж гэмээнэ төр иргэддээ үйлчлэх эрхэм үүргээ сайн биелүүлнэ. Сайн төрийн сүр хүч төрийн албандаа л байна. Төгс төгөлдөр биш юм аа гэхэд "улс төрийн салхи шуурга"-нд үл автах тийм алба бүрдэх зөв зарчмыг хууль зүйдээ суулгах нь нэн чухал байна.